



СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.17. №76 (76)

УИХ-ЫН ГИШҮҮД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫГ ДЭМЖИХЭЭ ИЛЭРХИЙЛЭВ



УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүд өнөөдөр Батлан хамгаалах яаманд ажиллалаа.

УИХ-ын гишүүд эхлээд “Бүх цэргийн их хар сүлд”-д хүндэтгэл үзүүлж, үргэлжлүүлэн Зэвсэгт хүчинд шинээр нэвтрүүлж буй инновац, шинэ бүтээл, оновчтой санал санаачилга шингэсэн зэвсэглэл, цэргийн техник, холбоо болон өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан үйлдвэрлэсэн цэргийн зориулалттай автомашинуудтай танилцав. Дараа нь тус яамны үйл ажиллагаа, Батлан хамгаалах салбарын 2020-2024 онд дэвшүүлсэн бодлого зорилт, хэрэгжүүлж буй ажлууд болон Зэвсэгт

хүчний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл сонссон юм.

Байнгын хорооны гишүүд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжүүлэхэд төрийн бодлогоор дэмжих нь зайлшгүй чухал гэдгийг онцолж, өөрсдийн санал бодол, байр сууриа илэрхийлсэн. Түүнчлэн урьдын адил Батлан хамгаалах салбарыг зэвсэглэл, цэргийн техникээр хангах, алба хаагчдын цалин хангамж зэргийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарсан бодлого боловсруулж ажиллана гэв. Төгсгөлд нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр БХЯ, ЗХЖШ-ын удирдлагуудад үүрэг чиглэл өглөө.

Тус байнгын хорооны дарга

Б.Баттөмөр энэ үеэр хэлэхдээ “Монгол төрийн бодлого нь эх орныхоо аюулгүй байдлыг сахин хариуцаж яваа Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийхээ үйл ажиллагааг улам төгөлдөржүүлэхэд чиглэгддэг. Монгол Улсын Зэвсэгт хүчин өнөөдөр даян дэлхийд баатарлаг цэргийн алба хаагчдын чадварлаг үүрэг гүйцэтгэлтийн ачаар алдаршиж, хүлээн зөвшөөрөгдөж байна. Монгол Улсын энхийг сахиулах ажиллагааны оролцоог төр засаг үргэлж дэмжиж ажиллана. Хоёрдугаарт, Зэвсэгт хүчин үндсэн үүрэг гүйцэтгэлтээс гадна улс орныхоо стратегийн бүтээн байгуулалтад оролцож байгаад талархаж байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт

хүчин төр засгаа харж суулгүйгээр дотооддоо цэргийн зориулалттай автомашин бүтээж, зэвсэглэлийнхээ чанарыг нэмэгдүүлсэнд баяртай байна. Удахгүй 2022 оны улсын төсвийг хэлэлцэнэ. Энэ үеэр батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дэмжиж ажиллах болно” хэмээн онцолсон юм.

Мөн УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар “Тус салбар богино хугацаанд их ахиц дэвшил гаргасан байна. Төсөв байхгүй гэж гар харалгүйгээр өөрсдийн нөөц бололцоо, хүчин чадлыг дайчилж, олон бүтээлч ажлын ард гарсныг хараад бахархлаа. Зэвсэгт хүчний алба хаагчдыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах шийдвэрийг анх гаргалцаж явсан хүний нэг нь би. Тухайн үед ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах явцад олон талаар учир дутагдалтай байсан. Олон улсын стандартад нийцсэн зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжүүд шаардлагатай байсан тэр үетэй харьцуулахад их зүйл өөрчлөгдсөн нь өнөөдөр бүр ч их мэдрэгдлээ. Батлан хамгаалах яам, ЗХЖШ-т ирэх бүрд энэ салбар өмнөхөөсөө шат ахисан байдаг нь мэдрэгддэг. Зэвсэгт хүчинд шинээр нэвтрүүлж буй инновацын бүтээл, зэвсэглэл, техникийг монгол инженер, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор зохион бүтээж, улмаар үйлдвэрлэж байгаа нь тун сайшаалтай.

Батлан хамгаалах салбар мэдлэгт суурилсан салбар болж байгаа нь хамгийн чухал. Аливаа улсын батлан хамгаалах чадвар гэдэг нь зөвхөн цэрэг, сумаар хэмжигдэхгүй. Мэдлэг, инженерүүдийн тооцоолох ухаан, чадварт суурилдгийг мэдэрч, нөөц бололцоогоо ашигласан нь өнөөдөр дэлгэж тавьсан зэвсэглэл, техникүүдээс тодорхой харагдлаа. Цаашид энэ ажил үргэлжлэх ёстой. Харин төрөөс бодлогоор дэмжсэн шиг дэмжих хэрэгтэй” гэлээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
14	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
29	16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.442.00	3.484.00
CNY	442.50	446.60
RUB	38.90	40.60
JPY	25.61	26.10
KRW	2.46	2.60

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 7
2021.06.17.
/ПҮРЭВ ГАРАГ/

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ХОЁР ХАР УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:
04.52-20.54

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал:

Гал

Аргын тооллын 7 сарын 17, Бархасвадь гараг. Билгийн тооллын 7, Бага морь одтой, улаан бич өдөр. Өдрийн наран 4 цаг 52 минутад мандан, 20 цаг 54 минутад жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хараал жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсон зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

НОМЫН ЦАГААН БУЯН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ



юм.

Эдгээр номыг батлан хамгаалах болон цэргийн мэргэжилтэн, цэргийн мэргэшсэн судлаач, багш нар болон аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаанаар магистр, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалахаар суралцагчид, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгаа хариуцсан төрийн албан тушаалтнууд, цэргийн дээд боловсролтой бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, генералууд, мөн сонирхогчид ашиглах боломжтой. Тодруулж хэлбэл, цэргийн операцийн ба тактикийн суурь мэдлэгтэй хүмүүст зориулжээ.

“Цэргийн ерөнхий тактик” номын нээлт өчигдөр ҮБХИС-д болов. Номын баярт Батлан хамгаалахын дэд сайд, БХЯ-ны ШУТЗ-ийн дарга, Б.Баярмагнай, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, Төслийн зөвлөх, редактор ҮБХИС-ийн профессор Ц.Дашзэвэг болон БХЯ, ЗХЖШ, ҮБХИС, Төрийн цэргийн командлалын удирдлага, төлөөлөл оролцлоо.

“Цэргийн ерөнхий тактик”, “Цэргийн операцийн урлаг” хэмээн

хоёр бүтээл нь орчин цагийн Зэвсэгт хүчин болон ҮБХИС үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын эрдэмтэн судлаачдын барьж буй бэлэг юм. Дээрх хоёр ном нь цэргийн нэгтгэлийн хэрэгслээр цэргийн операц, байлдаан явуулах, тусгай болон дайны бус цэргийн ажиллагаанд оролцох (уламжлалт бус цэргийн “дайны бус” ажиллагааны) онол, арга зүй, гадаадын зарим улсын цэргийн операц, тактикийн туршлага,

сургаж, Зэвсэгт хүчний цэргийн бүлэглэл, нэгтгэл операц, байлдаанд бэлтгэх, түүнийг явуулах онол, арга зүйн үндэс, өнөөгийн практикийг шинжилсэн, эрэл хайгуулд хөтөлсөн хамтын нэг сэдэвт бүтээл



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

83.128

ЭДГЭРСЭН

58.649

НАС БАРСАН

389/9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

3001 (44)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

363

ЭДГЭРСЭН

2592

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 177,421,807

Эдгэрсэн

Нийт: 161,873,295

Нас барсан

Нийт: 3,838,819



ҮЙЛ ЯВДАЛ

“ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ” СУРГУУЛИЙН 6 ДАХ УДААГИЙН ТӨГСӨЛТ БОЛОВ



ҮБХИС-ийн нэгэн эд эс болж их хааныхаа нэрээр овоглосон “Тэмүүжин Өрлөг” сургуулийн 6 дахь удаагийн төгсөлтийн ёслолын арга хэмжээ өчигдөр боллоо. Тус арга хэмжээнд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан, “Тэмүүжин Өрлөг” сургуулийн захирал, дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ болон эрдэмтэн багш сурагчид байлцлаа.

Цар тахлын хүнд цаг үед хоёр жилийн хугацаанд

мэргэжлийн багш, гал тогоо болон үйлчилгээний ажилчидтайгаа хамт нэг сарын хугацаанд элсэлтийн ерөнхий шалгалтдаа хамрагдсан юм. Энэ нь нийслэл хотын хүрээнд цор ганц тохиолдол гэж хэлж болох юм.

Энэ жил тус сургуулийг хоёр бүлгийн 64 сурагч төгсөж байгаа бөгөөд төгсөгчдийн дунд сурлага, урлаг, спортын амжилтаараа нөхдийгөө манлайлан амжилттай суралцсан олон сурагч байгаа аж. Мөн төгсөгчдийн

дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ ёслолын арга хэмжээний үеэр нийт төгсөгчдөдөө хандан “Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, нийгмийн амьдралын хурдацтай өөрчлөлтийн эрин үед хүний мэдлэг, эзэмшсэн мэргэжлийн ур чадвар хамгаас чухалд тавигдаж буйг санаж, суралцахуйн бэрхшээл түр зуурынх, харин мэдэхгүйн зовлон мөнхөд үргэлжилдэг болохыг ухамсарлан тодорхой зорилготой байж тасралтгүй суралцахыг чухалчлаарай. Хамгийн хэцүү тулаан бол өөртэйгөө хийх тулаан, хамгийн гайхалтай ялалт бол өөрийгөө ялах ялалт байдаг. Иймд сэтгэл хөдлөлөөр бус өөрийн чин хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ мэргэжлээ зөв сонгон амжилттай суралцах нь та бүхний цаашдын амьдралын утга учир, баталгаа болдгийг захиж хэлье” гэв. Мөн тэрээр цааш нь хэлэхдээ бид бүгдийн нэг сарын хугацаанд хамтран вакуумжуулсан сургалтад хамрагдсаны үр дүн ирэх сарын 1, 2-ны өдрүүдэд болох элсэлтийн ерөнхий шалгалтын та бүгдийн дүнгээр дүгнэгдэх болно хэмээн хэлж байлаа.



цахимаар хичээллэж байсан хэдий ч тус сургуулийн төгсөх ангийн сурагчид сургуулийнхаа материаллаг баазыг түшиглэн дотуур байрандаа цэргийн алба,

80 гаруй хувь нь ҮБХИС болон Төрийн цэргийн болон хууль сахиулах чиглэлийн сургуулиудад элсэн орох зорилготой ажээ. Тус сургуулийн захирал,

ЦАХИМ ШУУДАНД

УЛААНГОМ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД “ЦЭРГИЙН ЭРДМИЙН ТАНХИМ”-ТАЙ БОЛОВ

Увс аймгийн ЗДТГ-ын газрын Цэргийн штаб



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийн 4.2.4-д зааснаар өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллежид “Цэргийн эрдмийн танхим” байгуулж, оюутан суралцагчдыг сэтгэл зүй, бие бялдрын өв

тэгш хүмүүжилтэй болгох, шаардлагатай үед эх орноо хамгаалах цэргийн анхан шатны бэлтгэл эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна гэж заасан. Энэ хүрээнд хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх үүднээс Цэргийн штабаас санаачлан Улаангом политехник коллежтэй хамтран Цэргийн эрдмийн

“Соёмбо” танхимыг байгууллаа. Тус цэргийн эрдмийн танхим нь өсвөр үе, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох, цэргийн бэлтгэл үүрэгтний сургалтуудыг зохион байгуулахад чухал ач холбогдолтой юм. Танхим байгуулахад орон нутгийн төсвөөс 3 сая гаруй төгрөгийг шийдвэрлүүлсэн юм.

Хошууч Ж.ЦЭРЭНЧИМЭД

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР...



ЗХЖШ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн ээлжит хурал энэ сарын 15-нд боллоо.

Хуралд Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын салбар зөвлөлийн төлөөлөл цахимаар оролцсон юм. ЗХЖШ-ын нэгдүгээр

орлогч дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, сахилгын зөрчилгүй хамт олон болоход дэвшилтэд шинэлэг арга ашиглах ёстойг дурдав. Мөн алба хаагчдынхаа

хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхээс гадна бие хүний онцлог, сэтгэл зүй, гэр бүл рүү чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг давхар явуулахыг үүрэг болголоо. Түүнчлэн удирдах албан тушаалтнуудыг үүрэг хариуцлагаа нэмэгдүүлж, бие бүрэлдэхүүнийхээ сахилга бат, дэг журмыг сайжруулахад гол анхаарлаа хандуулж ажиллахыг даалгасан юм.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААН



Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Үндэсний их баяр наадмыг үзэгчгүй зохион байгуулна

Коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаар Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцууллаа.

Үйл ажиллагааг нь нээсэн худалдаа, үйлчилгээний салбаруудын цагийн хуваарьт хязгаарлалт, зохицуулалт хийж халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллаж байна. Тухайлбал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг долоо хоногийн хугацаатай заагаар үйлчлэхийг хориглож, амралт жуулчны баазын үйл ажиллагааг энэ сарын 17-ны өдөр буюу өнөөдөрөөс долоо хоног хязгаарлалаа.

Мөн Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ цар тахлын энэ үед аймаг, сумын наадам хийхгүй, Үндэсний их баяр наадмыг үзэгчгүй зохион байгуулах чиглэл өглөө. Хэмнэгдэх зардлыг цар тахлын хариу арга хэмжээнд зарцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулав

Коронавируст халдвар цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгаа сэргээх зорилготой 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Ажлын байрыг дэмжих зээл олголт энэ сарын 14-ний өдрийн байдлаар 65.7 хувь, репо санхүүжилтийн зээл олголт 24.9 хувь, орон сууцны ипотекийн

зээл олголт 2021 онд төлөвлөсөн хэмжээний 38 хувьд хүрээд байна. Мөн 15784 зээлдэгчдэд хөдөө аж ахуйг дэмжсэн 207.5 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөг хүртлэх зээлийг банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгож, зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглах зохицуулалт хийж байна.

Энэ сарын 14-ний байдлаар нийт 6.060.9 тэрбум төгрөгийн 57.7 мянган зээлийн хүсэлт ирүүлснээс 1.313.8 тэрбум төгрөгийг нийт 17785 иргэн, аж ахуйн нэгжид олгоод байна.

Агаарын тээвэр, аялал жуулчлалын талаар дараах арга хэмжээг авна

Аялал жуулчлал болон агаарын тээврийн салбарыг богино хугацаанд эргэн сэргээх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий Агаарын тээвэр, аялал жуулчлалын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол гаргахаар болов.

Тогтоолд агаарын тээвэр болон аялал жуулчлалын салбарыг харилцан уялдаатай хөгжүүлэх чиглэлээр хамтарсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, жуулчин тээврийн нислэгийн тоо, давтамж, чиглэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах зохицуулалт бүрдүүлэхээр тусгалаа.

Мөн аялал жуулчлалыг дэмжих тусгай тарифын бодлого баримталж, гадаадын улс оронд сурталчлан таниулах, жуулчны урсгал, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан шинээр нислэгийн чиглэл нээх, нислэгийн суудал ашиглалт үр

өгөөжийг нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм байна.

Аймгууд Соёлын хэлтэстэй боллоо

Аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төсөлд өөрчлөлт оруулж “Боловсрол, соёл урлагийн газар” гэснийг Боловсролын газар, Соёлын хэлтэс гэж өөрчилж, соёл урлагийн чиг үүргийг орон тоо, цалингийн сан, түүнд ногдох үйл ажиллагааны зардлын хамт шинээр байгуулах Соёлын хэлтэст холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь хэвийн явуулах нөхцөлөөр хангахыг холбогдох хүмүүст үүрэг болголоо.

Соёлын хэлтэс бий болсноор соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амыг бүх нийтийн соёлын боловсролоор дамжуулан соён гэгээрүүлэх, соёлын өвөө хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх төрийн соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймагт байгуулна

Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засах цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, тэдний хөгжлийг дэмжих чиг үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулна.

Дээрх аймгуудад төвийн барилгын ажлыг эхлүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэж байна. Төвүүдийн үйл ажиллагааг 2022 оноос эхлүүлэхээр төлөвлөжээ.

Эх сурвалж: Засаг.мн